

“Ди Би Эм Ассет Менежмент” ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2017 оны 11 дүгээр сарын 01-ны
өдрийн 05 дугаар тогтоолын Хавсралт 1



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ДОТООД ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Ди Би Эм Ассет Менежмент” ХХК /цаашид “компани” гэх/-ийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх болон энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээдэд хариуцлага ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон уг хуульд нийцүүлэн гаргасан холбогдох бусад журамд нийцсэн байна.

1.3. Компани нь Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (Financial Action Task Force буюу ФАТФ)-ны зөвлөмжид заасан шаардлагуудыг биелүүлж ажиллана.

Хоёр. Журамтай холбогдох нэр томъёоны тодорхойлолт

2.1. Журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Мөнгө угаах” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.1-д заасныг ойлгоно,

2.1.2. “Терроризмыг санхүүжүүлэх” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.2-д заасныг ойлгоно,

2.1.3. “Бэлэн мөнгөний гүйлгээ” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.3-д заасныг ойлгоно,

2.1.4. “Сэжигтэй гүйлгээ” гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, эсхүл мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж компани үзсэн гүйлгээг,

2.1.5. “Санхүүгийн мэдээллийн алба” /цаашид “СМА” гэх/ гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Монголбанкин дахь нэгжийг,

2.1.6. “Эрх бүхий байгууллага” гэж гүйцэтгэх ажил болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих эрх бүхий прокурорын байгууллагыг,

2.1.7. “Харилцагч” гэж компанитай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгөө итгэмжлэн удирдуулж байгаа болон компанийн удирдаж байгаа хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулагч этгээдийг,

2.1.8. “Хэрэгжүүлэгч ажилтан” гэж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай холбогдох хууль, уг журмыг хэрэгжүүлэгч комплаенс асуудал хариуцсан ажилтанг,

2.1.9. “Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан” гэж Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон холбогдох журмыг хэрэгжүүлэгч ажилтанд хяналт тавих ажилтанг.

Гурав. Урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаа

3.1. Компани нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд хөрөнгө оруулалтын санд хөрөнгө татан төлөвлөрүүлэх болон сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдахдаа дараах үйл ажиллагааг явуулна.

3.1.1. Компанийн хэрэгжүүлэгч ажилтан нь дараах тохиолдолд харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдсэний үндсэн дээр хэрэв сэжигтэй гэж үзсэн тохиолдолд харилцагчаас холбогдох нэмэлт мэдээллийг гаргуулан авч, энэ тухай хэрэгжилтэд хяналт тавих ажилтанд мэдэгдэн, шаардлагатай гэж үзвэл СМА-д мэдээллийг хүргүүлнэ.

3.1.1.1. санхүүгийн харилцаа үүсгэхийн өмнө,

3.1.1.2. харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхэд эргэлзсэн тохиолдолд,

3.1.1.3. тухайн харилцагч, тухайн гүйлгээ /санхүүгийн эх үүсвэр/-г мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж сэжиглэсэн тохиолдолд,

3.1.1.4. эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй болон улс төрд нөлөө бүхий этгээдийн нэр дээр хийсэн гүйлгээ,

3.1.1.5. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүрэг бүхий олон улсын байгууллагаас мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж тодорхойлогдсон улсаар дамжуулан хийсэн гүйлгээ.

3.1.2. Компанийн хэрэгжүүлэгч ажилтан нь дараах гүйлгээнүүд гарсан тохиолдолд хэрэгжилтэд хяналт тавих ажилтанд хянуулсны үндсэн дээр мэдээллийг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Монголбанкнаас баталсан маягтын дагуу СМА-д мэдээлнэ.

3.1.2.1. хорин сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор,

3.1.2.2. хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор,

3.1.2.3. харилцагч нь Нэгдсэн Үндэсний Байгууллага болон дотоодын эрх бүхий байгууллагаас террорист гэж зарласан этгээдийн нэртэй тохирч байвал эсхүл сэжигтэй гэж үзсэн тохиолдолд нэн даруй Тагнуулын ерөнхий газарт мэдэгдэж гүйлгээ болон гүйлгээ хийх оролдлогыг 24 цагийн дотор,

3.2. Компанийн хэрэгжүүлэгч ажилтан нь энэхүү журмын 3.1.2-т заасан мэдээллээ утсаар СМА-д хүргэсэн бол түүнийгээ нэн даруй факс буюу бичгээр баталгаажуулна.

3.3. Компани нь хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх аливаа үйл ажиллагаанд ашиглахгүй, санхүүжүүлэхгүй байхыг удирдлага болгон ажиллана.

Дөрөв. Мэдээллийн нууцлалыг хадгалах

4.1. Хэрэгжүүлэгч ажилтан болон хэрэгжилтэд хяналт тавих ажилтанд дараах үйл ажиллагааг хориглоно.

4.1.1. Хууль тогтоомжийн дагуу харилцагч өөрөө мэдээлэхийг зөвшөөрсөн хувь хүн, хуулийн этгээдээс өөр хувь хүн, хуулийн этгээдэд харилцагчийн гүйлгээний талаар мэдээлэх,

4.1.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу эрх олгогдсон байгууллагын албан ёсоор томилогдсон албан тушаалтнаас өөр хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэх.

Тав. Эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх, баримт материалыг хадгалах

5.1. Хэрэгжүүлэгч ажилтан нь компанийн удирдлагын зөвшөөрлийг үндэслэн эрх бүхий байгууллагын бичгээр тавьсан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 7 өдрийн дотор бичгээр хариу өгнө.

5.2. Эрх бүхий байгууллагын хүсэлт нь хүсэлт гаргах үндэслэл, тодорхой этгээдийн хүсч буй мэдээллийн төрөл, мэдээллийг хүлээн авах хэлбэрийг тодорхой тусгасан байна.

5.3. Хэрэгжүүлэгч ажилтан нь харилцагчийн талаарх мэдээллийг бизнесийн харилцааны туршид цуглуулан, холбогдох бүх баримт бичгийг тухайн данс хаагдсан, бизнесийн харилцаа дуусгавар болсон болон гүйлгээ хийгдсэнээс хойш таваас доошгүй жилийн хугацаанд эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1. Хэрэгжүүлэгч ажилтан нь санаатайгаар худал мэдээлэл өгсөн эсхүл тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг гаргаж өгөөгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Хэрэгжүүлэгч ажилтныг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж энэ журмыг хэрхэн хэрэгжүүлж буйд хэрэгжилтэд хяналт тавих ажилтан хяналт тавин ажиллана.

6.3. Хэрэгжүүлэгч ажилтан болон хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь СМА-д мэдээлсэн тайлан, түүнтэй холбоотой нэмэлт мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцна .

6.4. Хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь дараах эрх, үүрэгтэй байна.

6.4.1. харилцагч болон гүйлгээний талаарх баримт, мэдээлэлтэй танилцах, шаардлагатай мэдээллийг холбогдох ажилтнаас гаргуулан авах эрхтэй,

6.4.2. СМА-ны болон бусад дотоод, гадаадын байгууллагаас зохион байгуулсан сургалт, семинарт удирдлагын зөвшөөрлөөр хамрагдах эрхтэй,

6.4.3. мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын талаар компанийн Гүйцэтгэх удирдлагад жилд нэгээс доошгүй удаа тайлагнах үүрэгтэй,

6.4.4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд нэгээс доошгүй удаа компанийн бусад ажилтнуудад зориулсан сургалт явуулах үүрэгтэй.

6.5. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХААС СЭРГИЙЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь “Ди Би Эм Ассет Менежмент” ХХК (цаашид “Компани” гэх)-иас Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос баталсан холбогдох журмын хэрэгжилтийг хангах хүрээнд компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд нь үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллана.

1.3. Холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан журамд өөрчлөлт орсон болон бусад шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.

1.4. Тус компани нь эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудад үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох, таниулах үйл ажиллагааг дотооддоо тогтмол зохион байгуулж ажиллана.

1.5. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос баталсан холбогдох үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх журамд зааснаар ойлгоно.

Хоёр. Үйл ажиллагааны зарчим болон мэргэжлийн ёс зүй

2.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах зарчмуудыг үйл ажиллагаандаа баримтална.

2.1.1. Мэргэжлийн ёс зүйтэй байх;

2.1.2. Бүх харилцагчдад тэгш шударга, хараат бусаар үйлчлэх;

2.1.3. Харилцагчийн ашиг сонирхлыг өөрийн ашиг сонирхлоос тэргүүнд тавих;

2.1.4. Хууль бус аливаа үйлдлийг мэдээлэх;

2.1.5. Үнэт цаасны зах зээлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллах.

Гурав. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйл ажиллагаа

3.1. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйл ажиллагаанд үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан үнэт цаасны зах зээлд хуурамч арилжаа хийх, үнэ ханшийг зохиомлоор тогтоох, үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг хууран мэхлэх замаар арилжаанд оролцуулахгүй байх, бусад арга хэлбэрээр оролцох үйл ажиллагааг хамааруулна.

3.2. Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааны хүрээнд дор дурдсан байдлаар үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйл ажиллагаа үүсч болно.

3.2.1. Үнэт цаасны арилжаанд үнэт цаасны зах зээлд оролцогч, харилцагчийг төөрөгдүүлэх зорилгоор тодорхой үнэт цаасны өмчлөгч нь өөрчлөгдөөгүй боловч арилжаа идэвхтэй явагдаж байгаа дүр үзүүлэн хэлцэл хийх, үнэт цаасны арилжааны явцад болон үнэт цаасны үнэ ханшийг бусадтай үгсэн хуйвалдаж зохиомлоор тогтоох, барих, өсгөх, бууруулах үйлдлийг хамруулна,

3.2.2. Дотоод мэдээлэлд үнэт цаасны үнэ ханш болон хөрөнгө оруулагчийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлж болох дотоод мэдээлэл буюу харилцагчтай байгуулсан гэрээ, үнэт цаас эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд ажиллах бодлого, зорилго үйл ажиллагаатай холбогдсон мэдээ баримт, бусад материалд орсон нийтэд тараагдаагүй мэдээ баримтуудыг нийтийн хүртээл болохоос өмнө ашиглан арилжаанд оролцох, бусдад дамжуулах, зах зээлд нөлөө үзүүлэх зорилготой захиалга өгч, түүний нөлөөгөөр зах зээлд гарсан өөрчлөлтөөс ашиг олох гүйлгээ хийх зэрэг хамаарна,

3.2.3. Бусад арга хэлбэрт олон нийтийн хэрэгсэл болон интернет ашиглан олон нийтийг төөрөгдөлд оруулсан, бодит бус хуурамч мэдээлэл цацах эсхүл амлалт өгөх замаар үнэт цаасны үнэ ханш болон эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөхөөр хуурамч мэдээлэл тараах, зохицуулалттай этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан өөрсдийн мэдэлд байгаа мэдээллээ давуу байдалтайгаар ашиглахаас хамаарна.

Дөрөв. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх

4.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь үндсэн чиг үүрэг болон өөрийн ажил үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны хүрээнд бүртгэлийн болон мэдээлэл, тайлагналыг бүрдүүлэхдээ үнэ ханшийг зохиомлоор тогтоох, зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлж ажиллана.

4.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос баталсан үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх журамд заасан нийтлэг үүргээс гадна дараах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

4.2.1. Компанийн ажилтан нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхээс өмнө энэ талаарх мэдээллийг компанийн Гүйцэтгэх удирдлагад мэдэгдэх,

4.2.2. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх талаар асуудлуудыг удирдлагад тайлагнан, цаг тухайд нь шийдвэрлүүлэх,

4.2.3. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах үйлдэл санаатай болон санамсаргүйгээр гарсан тохиолдолд зөрчлийг нэн даруй компанийн дотоод хяналтын ажилтанд мэдээлэх,

4.2.4. Компанийн ажилтан нь Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг зөрчсөн, зах зээлийг урвуулан ашиглах зорилго агуулсан харилцагчийн захиалгыг хүлээн авахаас татгалзах,

4.2.5. Компанийн үйл ажиллагаагаар дамжуулан оролцох шаардлагатай болсон их хэмжээний болон ханшийн өсөлт бууралттай арилжааны захиалгыг холбогдох хууль тогтоомж, журамд нийцсэн эсэхийг магадлан баталгаажуулах,

4.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд холбогдох этгээдийн хувийн дансаар үнэт цаасны арилжаанд оролцдог бол үүнтэй холбоотой мэдээллийг компанийн дотоод хянан нийцүүлэх үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэх ажилтанд тогтмол мэдээлж, шинэчилсэн мэдээллийг тухай бүр мэдээллийн санд оруулна.

4.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудад дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

4.4.1. Харилцагчийн олон нийтэд мэдээлэгдээгүй, үнэт цаасны ханшид нөлөөлж болохуйц арилжааны мэдээ, санхүүгийн болон бусад нууц мэдээллийг ашиглах, бусдад дамжуулах болон задруулах,

4.4.2. Харилцагч байгууллагын эрх ашгийг компанийн эрх ашгаас дээгүүр тавих, учирч болох эрсдэлийг санаатайгаар нуух, хуйвалдах,

4.4.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь үнэт цаасны арилжаатай холбоотой хууль тогтоомжоор хориглосон арилжаа эсхүл нууцын зэрэглэлтэй, үнэ ханшид нөлөөлж болох мэдээлэлд тулгуурлан хийгдсэн гүйлгээг гүйцэтгэх,

4.5. журмын 3.2-т заасан үйлдэл хийгдэхээс сэргийлсэн бүртгэлийн болон мэдээлэл, тайлагналын давхар хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллана.

Тав. Хяналт тавих

5.1. Энэхүү журмын хэрэгжилтэд компанийн дотоод хяналтын алба хяналт тавин.

5.2. Энэхүү журмыг зөрчиж, хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хориглосон үйл ажиллагаа явуулсан эрх бүхий албан тушаалтан, ажилтанд холбогдох хууль тогтоомж, журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.